



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

10.12 - 10.16



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: АНУ-д зах зээлийн үнэлгээ өндөртэй компаниудаас бүрдэх индексүүд бага зэрэг өсөлттэй хаагдсан бол зах зээлийн үнэлгээ багатай компаниудаас бүрддэг индексүүд бага зэрэг бууралттай хаагдлаа. S&P 500 индексийн сагсанд багтах үйлдвэрлэлийн болон ус, цахилгаан, дулааны салбарын компаниуд хамгийн их өсөлттэй байсан бол банкнуудын улирлын тайлан хөрөнгө оруулагчдын хүлээлтэд хүрээгүйтэй холбоотойгоор санхүүгийн салбар хамгийн их уналт үзүүлэв.

Зах зээлийн үнэлгээ өндөр технологийн компаниудын хувьцааны ханш өссөнөөр Даваа гарагт S&P 500 индекс энэ долоо хоногийн дээд хэмжээндээ хүрсэн байна. Тухайлбал, Мягмар гарагт Apple компани шинэ загварын iPhone гар утсаа танилцуулах болсонтой холбоотойгоор хүлээлт үүссэн бол Amazon.com компани энэ жилийн "Prime Day"-ийг 10-р сарын 13-14-ний өдрүүдэд зохион байгуулахаар болсон нь Даваа гарагт тус компаниудын хувьцааны ханш өсөхөд нөлөөлжээ.

Европ: Коронавирусын халдварын тоо нэмэгдэж, Brexit-тэй холбоотой тодорхойгүй байдал үргэлжилсээр байгаа ба АНУ-аас эдийн засгийг дэмжих хөтөлбөрийг 11-р сарын 3-ны өдрийн сонгуулиас өмнө батлах магадлал буурч байгаатай холбоотой Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт бууралттай хаагдлаа. ХБНГУ-ын ЗГҮЦ-ыг хөрөнгө оруулагчид их хэмжээгээр худалдан авч эхэлсэнтэй холбоотойгоор ХБНГУ-ын ЗГҮЦ-ны өгөөж энэ оны 3-р сараас хойших хамгийн доод хэмжээндээ хүрчээ. STOXX Europe 600 индекс 0.78%-аар, Xetra DAX индекс 1.09%-аар, CAC 40 индекс 0.22%-аар, FTSE MIB индекс 1.05%-аар, FTSE 100 индекс 1.61%-аар тус тус буурсан байна.

Япон: Энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд бууралттай хаагдлаа. Nikkei 225 индекс 209 нэгжээр буюу 0.9%-аар буурч 23,410.63 нэгж дээр хаагдсан нь энэ оны эхэн үетэй харьцуулахад 1.0%-аар унасан байна. Япон улсын хөрөнгийн зах зээлийг бүхэлд нь илтгэх large-cap TOPIX болон TOPIX small индексүүд мөн бууралттай хаагджээ.

Япон улсын Засгийн газар цар тахалтай холбоотой их хэмжээгээр буураад байгаа хувийн хэрэглээг нэмэгдүүлэх гуравдах хөтөлбөрөө боловсруулж байна. Ерөнхий сайд Ёшихидэ Суга уг саналын талаар ирэх сард тодорхой зөвлөмж өгөхийг хүссэн бөгөөд ингэснээр уг багц хуулийн төслийг оны эцсээр боловсруулж, ирэх 1-р сард өргөн барих боломжтой юм.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдсан байна. Shanghai Composite индекс 2.0%-аар, CSI 300 индекс 2.4%-аар тус тус өссөн байна. Мөн БНХАУ-ын 9-р сарын худалдааны статистик сайн гарсан нь эдийн засгийн сэргэлтийн хурд тогтвортой байгааг харуулж, БНХАУ-ын 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж 4 функтээр нэмэгдэн 3.25% болсон байна. Өнгөрсөн сард БНХАУ-ын Засгийн газрын гадаад бондын худалдан авалт өндөр байсан ба гадаад хөрөнгө оруулагчид 20.2 тэрбум ам.доллартой тэнцэх БНХАУ-ын ЗГҮЦ худалдаж авсан байна. Хятадын Ардын Банкны (PBOC) эрх баригчид энэ сарын хэвлэлийн бага хурлын үеэр зээлийн хүүг бууруулах сонирхол багатай байгаагаа илэрхийлжээ.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	17,501.43	-0.57% ▼
Dow Jones	АНУ	28,606.31	0.07% ▲
S&P 500	АНУ	3,483.81	0.19% ▲
Nasdaq	АНУ	11,671.56	0.79% ▲
S&P/TSX	Канад	16,438.75	-0.75% ▼
FTSE 100	Их Британи	5,919.58	-1.61% ▼
S&P/ASX 200	Австрали	6,176.80	1.22% ▲
Nikkei 225	Япон	23,410.63	-0.89% ▼
Hang Seng	Хонг Конг	24,386.79	1.11% ▲

Бонд	Валют	Купон	Өгөөж
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	4.39%
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	3.92%
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	3.73%
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	2.05%
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	1.08%
DBM' 2023	USD	7.250%	5.14%
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	11.61%
Mongol 2026 (Номад)	USD	5.125%	4.45%

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.151	0.04 ▲
Libor 3M	0.218	-0.03 ▼
Libor 6M	0.258	0.05 ▲
Libor 1YR	0.335	-0.04 ▼
US 2YR Bond	0.149	-0.02 ▼
US 3YR Bond	0.188	-0.05 ▼
US 5YR Bond	0.330	-0.02 ▼
US 10YR Bond	0.759	-0.02 ▼

Валютын ханш	2020.10.16	Өөрчлөлт
USD	2,853.47	-0.04% ▼
CNY	425.7	0.14% ▲
EUR	3,343.13	-0.57% ▼
RUB	36.63	-1.03% ▼
KRW	2.49	0.00%
JPY	27.1	0.56% ▲
CAD	2,160.08	-0.31% ▼

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,899.29	-1.61% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	24.16	-3.96% ▼
Зэс	USD/lb.	306.75	-0.49% ▼
Нүүрс	USD/MT	57.63	-1.49% ▼
WTI газрын тос	USD/bbl.	40.88	0.69% ▲
Brent газрын тос	USD/bbl.	42.93	0.19% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.VIII	2.10%
Бодлогын хүү	2020.VIII	8.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.VIII	8.73%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.VIII	10.84%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.VIII	4.13%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.VIII	16.93%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.VIII	10.44%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 43 компанийн 905.4 сая төгрөгийн 12,378,731 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Дархан хөвөн” /MSE: DAH/ компанийн хувьцаа 10.58%-аар буюу хамгийн ихээр өсөж 6,580.00 төгрөг хүрч хаагдсан бол “Монинжбар” /MSE: MIB/ компанийн хувьцаа 15.78%-аар буурч 80.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй байна.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

10-р сарын 16-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,593.2 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 индекс 17,501.43 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.57%-аар буурсан байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	905.4	
Зах зээлийн үнэлгээ	2,593,190.0	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	17,501.43	-0.57% ▼
MSE I индекс	8,236.81	0.16% ▲
MSE II индекс	7,426.15	-0.81% ▼

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Женко тур бюро	4,705,921	447,062,495
Мандал даатгал	6,189,000	272,316,000
АПУ	58,107	33,118,539
Ард санхүүгийн нэгдэл	21,716	29,218,749
Монос хүнс	429,319	29,215,258

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Дархан хөвөн	6,580.00	10.58% ▲
Монгол базальт	190.00	3.92% ▲
Говь	199.06	2.60% ▲
Айтүүлс	78.90	1.54% ▲
БиДиСек	860.00	1.17% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Монинжбар	80.00	-15.78% ▼
Авто импекс	1,010.00	-14.69% ▼
Оллоо	45.00	13.46% ▼
Ремикон	23.27	-11.52% ▼
Монголын цахилгаан холбоо	375.00	-10.69% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
БиДиСек	955,595,756
Бумбат-Алтай	307,896,634
Гүүдсек	280,603,213
Ард секюритиз	66,528,777
Ти Ди Би Капитал	65,456,530

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	570.04	606,626.05
Таван толгой	5,795.00	305,194.83
МИК холдинг	12,790.00	264,872.20
Инвекор ББСБ	2,855.00	204,783.21
Говь	199.06	155,289.19

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-НД ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-НД ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НД ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-НД ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.08.06-НД ОЛГОВ
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.07.09-НД ОЛГОВ
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.09.07-НД ОЛГОВ
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.07.30-НД ОЛГОВ
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-НД ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-НД ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.07.08-НД ОЛГОВ
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-НД ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-НД ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.07.31-НД ОЛГОВ
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-НД ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.07.21-НД ОЛГОВ
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
35	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	530.2	65.1	12.3%	6.3	2020.09.09	2020.09.28-НД ОЛГОВ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Монголын хөрөнгийн биржид шинээр бүртгэгдсэн анхны хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан болох “Үндэсний хувьчлалын сан” хамтын ХОС-ийн гаргасан нэгж эрхийн 95% буюу 47.5 сая ширхэг нэгж эрхийг стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2020 оны 10-р сарын 05-ны өдрөөс 10-р сарын 16-ны өдрийн 16:00 цаг хүртэл авч дууслаа.

Анхдагч зах зээл дээр нийт 2,245 хувь хүн, аж ахуйн нэгжийн нийт 5,537,565,300 төгрөгийн үнэт цаас худалдан авах санал ирүүлсэн нь татан төвлөрүүлэх дүнгээс 16.5%-аар давсан үзүүлэлт боллоо.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” /TSX: ERD, MSE: ERDN/ ХК-ийн 11.2 хувийг ЕСБХБ эзэмшихээр боллоо.

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” /TSX: ERD, MSE: ERDN/ ХК (цаашид “Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (“ЕСБХБ” эсвэл “EBRD”) -аас авсан 5 сая ам.долларын хөрвөх нөхцөлтэй зээлийн хүрээнд ЕСБХБ нь хөрвүүлэх эрхээ хэрэгжүүлснийг мэдээлж байна. Дээрх хөрвөх боломжтой зээлийг хувьцаанд хөрвүүлсний үндсэн дээр ЕСБХБ нь 30,043,290 энгийн хувьцааг эзэмшсэнээр Компанийн гаргасан болон арилжигдаж буй нийт энгийн хувьцааны 11.2%-ийг эзэмшинэ.

Компанийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли “ЕСБХБ-ны хөрвөх нөхцөлтэй зээлийн санхүүжилтээр Баян Хөндий Алтны Төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг эцэслэсэн. ЕСБХБ-ны хөрвүүлэлт болон ноён Эрик Спроттын 15 сая канад долларын хөрөнгө оруулалт бүхий 20 сая канад долларын санхүүжилт нь Эрдэнэ Ресурсийн Баян Хөндий төслийг олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэхэд шаардлагатай төслийн санхүүжилтийг татан төвлөрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Компани нь 2022 онд алтны үйлдвэрлэлтийг эхлүүлэхээр төлөвлөн, Баян Хөндий төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлуудыг эхлүүлж, дүүргийн хэмжээнд нөөц нэмэгдүүлэхэд чиглэн ажиллаж байна.” гэж мэдэгдсэн байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Мандал даатгал” /MSE: MNDL/ ХК-ийн 6.2 сая ширхэг хувьцаа багцаар арилжаалагдлаа.

2020 оны 10-р сарын 14-ний өдөр Монголын Хөрөнгийн Биржийн I ангилалд бүртгэлтэй “Мандал даатгал” /MSE: MNDL/ ХК-ийн 6,189,000 ширхэг хувьцааг нийт 272,316,000 төгрөгөөр буюу нэгж хувьцааг 44 төгрөгөөр багцаар арилжаалсан байна. Энэхүү арилжаа нь тус компанийн хоёрдогч зах зээлийн арилжаа 2018 онд эхэлснээс хойших хамгийн анхны багцын арилжаа байлаа.

“Женко тур бюро” /MSE: JTB/ ХК-ийн 4.7 сая ширхэг хувьцаа багцаар арилжаалагдлаа.

2020 оны 10-р сарын 16-ны өдөр Монголын Хөрөнгийн Биржийн II ангилалд бүртгэлтэй “Женко тур бюро” /MSE: JTB/ ХК-ийн 4,705,921 ширхэг хувьцааг нийт 447,062,495 төгрөгөөр буюу нэгж хувьцааг 95 төгрөгөөр багцаар арилжаалсан байна.

Тус компани дээр хамгийн сүүлд 2020 оны 9-р сарын 21-ний өдөр багцын арилжаа хийгдсэн ба тус арилжаагаар мөн 4,705,921 ширхэг хувьцааг нийт 447,062,495 төгрөгөөр буюу нэгж хувьцааг 95 төгрөгөөр багцаар арилжаалсан байна.

2020 онд тус компани дээр 5 удаагийн багцын арилжаа явагдсан ба нийт 20,878,177 ширхэг хувьцааг 1,983,426,815 төгрөгөөр багцаар арилжаалаад байна.

“АПУ” /MSE: APU/ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэр.

Монголын Хөрөнгийн Биржийн I ангилалд бүртгэлтэй “АПУ” /MSE: APU/ ХК-ийн 2020 оны 10-р сарын 2-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын үр дүнд:

- Тус компанийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгож, ердийн гишүүнээр П.Батсайхан, Б.Батбаяр, Сергей Громов, Кеннет Чу, Сэн И-Ин, Томас Холланд нарыг, хараат бус гишүүнээр Ө.Батбаяр, Ё.Гэрэлчулуун, Ж.Үнэнбат нарыг 3 жилийн хугацаатай сонгож.
- ТУЗ-ийн даргаар П.Батсайханыг сонгож.
- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороог Ж.Үнэнбат, Сэн И-Ин, Ө.Батбаяр, Нэр дэвшүүлэх хороог П.Батсайхан, Ө.Батбаяр, Ё.Гэрэлчулуун, Цалин урамшууллын хороог Ё.Гэрэлчулуун, Ж.Үнэнбат, Кеннет Чу гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах шийдвэрүүдийг тус тус гаргасан байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Олон Улсын Валютын Сангаас Монгол Улсын эдийн засгийг 2020 онд 2%-аар агшина гэж таамагласан нь өмнөх төсөөллөөс 1%-аар бууруулсан үзүүлэлт болсон ба 2021 онд 6%-аар сэргэж, 2025 он гэхэд 4.5%-д тогтворжино гэж дүгнэжээ.

Энэхүү таамаглал нь эдийн засаг 2.6%-аар агшина гэсэн Монголбанкны хүлээлттэй ойролцоо байгаа ба оны эхний хагас жилийн эдийн засгийн үзүүлэлтүүд тааруу байсан нь төсөөллийг шинэчлэхэд хүргэсэн байна. Инфляцын төсөөллийг энэ онд 4.5%, ирэх онд 6.6% байна гэж тооцоолсон нь мөн инфляцыг 2%-ийн интервалтайгаар 6%-д барих Монголбанкны зорилттой нийцэж байна.

Эх сурвалж: BloombergTV.mn



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 9-р сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.3%-аар буурч, өмнөх оны эцсээс 1.9%, өмнөх оны мөн үеэс 1.7%-аар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 9-р сард өмнөх оны мөн үеэс 1.7%-аар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.4% (согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 3.8%), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 4.7%, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 4.3%, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 2.9% (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 2.7%), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.0%-аар өссөн нь голлон нөлөөлсөн хэдий ч тээврийн бүлгийн үнэ 5.8%-аар буурсан байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 9-р сард өмнөх оны эцсээс 1.9%-аар өсөхөд хүнсний бараа, ундаа,

усны бүлгийн үнэ дүнгээрээ 5.6% (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 13.1%), хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 2.0%, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.9%-аар өссөн нь голлон нөлөөлсөн хэдий ч тээврийн бүлгийн үнэ 6.0%-аар буурсан байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 9-р сард өмнөх сараас 0.3%-аар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.3%-аар (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 5.0%), төмс хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 16.0%-аар буурсан байна. Харин хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.4%, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.3%-аар өссөн байна.

Инфляцын түвшин 2017 оны 9-р сард 5.8%, 2018 оны 9-р сард 5.7%, 2019 оны 9-р сард 9.0% гарч байсан бол 2020 оны 9-р сард 1.7% болж 7.3 пунктээр буурсан байна.

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний 9 сард урьдчилсан дүнгээр 11.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.3 (17.2%) их наяд төгрөгөөр буурлаа. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2.1 (21.5%) их наяд төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин цахилгаан хий, уур, агааржуулалтын салбарын үйлдвэрлэл 62.4 (7.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний 9 сард урьдчилсан гүйцэтгэлээр 7.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.1 (21.5%) их наяд төгрөгөөр буурахад нүүрс олборлолт 2.2 (52.8%) их наяд төгрөгөөр, газрын тос олборлолт 503.6 (66.0%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны 9-р сард 1.7 их наяд төгрөг болж, өмнөх сараас 270.1 (19.4%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 268.3 (28.0%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 2020 оны эхний 9 сард хайлуур жонш, төмрийн хүдэр болон алтны олборлолт өмнөх оны мөн үеэс 5.0-35.1 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт спирт, ус, ундаа, жүүс, согтууруулах ундаа, гурил, цемент, шингэн сүү, нүүрсэн шахмал түлш зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.6-56.9 хувиар тус тус өссөн байна.

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ БОЛОН ВАЛЮТЫН ХАДГАЛАМЖ


2020 онд коронавирусын цар тахалтай холбоотой дэлхийн эдийн засаг томоохон цохилтод орсон билээ. Энэхүү цар тахлаас хойш Монгол улсын мөнгөний нийлүүлэлт, түүний бүтэц хэрхэн өөрчлөгдсөн байгааг хүлээн авна уу.

Мөнгөний нийлүүлэлт (M2)

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2020 оны 3-р улирлын байдлаар 22.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 их наяд төгрөгөөр буюу 9.8%-аар өссөн байна. 2010 оноос хойш M2 мөнгөний хэмжээ жилд дунджаар (CAGR) 20.7%-аар өссөн байна.

M2 мөнгөний валютын жилийн өсөлт болон төгрөгийн жилийн өсөлтийг харьцуулж харахад 2019 оны 3-р улирлаас эхлэн валютын хэмжээний өсөлт 5 улирал дараалан төгрөгийн өсөлтийг давсан байна.

Зураг 1. Мөнгөний нийлүүлэлт (M2), 2020 он III улирал



Эх сурвалж: "Ти Ди Би Капитал УЦК" ХХК судалгаа

Зураг 2. M2 жилийн өсөлт, бүтцээр, 2020 он III улирал



Эх сурвалж: "Ти Ди Би Капитал УЦК" ХХК судалгаа

ШИНЖЭЭЧИЙН БУЛАН


МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ БОЛОН ВАЛЮТЫН ХАДГАЛАМЖ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Валютын харилцах, валютын хадгаламж

2020 оны 3-р улирлын байдлаар M2 мөнгөний валют 7.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 23.5%-аар өссөн байгаагаас валютын харилцах 2.1 их наяд төгрөг буюу 29.2%-ийг, валютын хадгаламж 5.1 их наяд төгрөг буюу 70.8%-ийг тус тус эзэлж байна.


Валютын хадгаламж дунджаар 2010 оноос 2019 оны хооронд нийт валютын 58.5%-ийн эзэлж байсан бол 2020 оны 3-р улиралд энэ хэмжээ 70.8% болтлоо өссөн байна. 2020 оны 3-р улиралд валютын хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 74.7%-ийн өсөлт үзүүлсэн бол валютын харилцахын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.8%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 3. Валютын харилцах, хадгаламж, 2020 он III улирал



Эх сурвалж: "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК судалгаа

Зураг 4. Валютын харилцах, хадгаламж, жилийн өсөлт, 2020 он III улирал



Эх сурвалж: "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК судалгаа

ШИНЖЭЭЧИЙН БУЛАН


МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ БОЛОН ВАЛЮТЫН ХАДГАЛАМЖ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Төгрөгийн харилцах, хадгаламж

2020 оны 3-р улирлын байдлаар М2 мөнгөний нийт төгрөгийн хэмжээ 15.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.2%-аар өссөн байгаа ба М1 мөнгө 3.6 их наяд төгрөг буюу 23.4%-ийг, төгрөгийн хадгаламж 11.6 их наяд төгрөг буюу 76.6%-ийг тус тус эзэлж байна.


Төгрөгийн хадгаламжийн жилийн өсөлтийн хэмжээ болон М1 мөнгөний жилийн өсөлтийн хэмжээ 2020 онд өмнөх 3 жилтэй харьцуулахад буурсан байна.

Зураг 5. Төгрөгийн харилцах, хадгаламж, 2020 он III улирал



Эх сурвалж: “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК судалгаа

Зураг 6. Төгрөгийн харилцах, хадгаламж, жилийн өсөлт 2020 он III улирал



Эх сурвалж: “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК судалгаа

ШИНЖЭЭЧИЙН БУЛАН


МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ БОЛОН ВАЛЮТЫН ХАДГАЛАМЖ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дээрх мэдээллээс харахад 2020 он гарснаас хойш М2 мөнгөний бүтцэд тодорхой хэмжээний өөрчлөлт гарсан байгаа ба М2 мөнгөний жилийн өсөлтийг авч үзэхэд сүүлийн 5 улирал дараалан валютын өсөлт төгрөгийн өсөлтийг давсан байгаа бол 2020 он гарснаас хойш М1 мөнгөний жилийн өөрчлөлт сөрөг байна.

М2 мөнгөний нийт төгрөгийн хэмжээ 2019 оноос хойш харьцангуй тогтвортой байгаа бол нийт валютын хэмжээ 2019 оноос хойш өсөх хандлагатай байна.

Анзаарагдаж буй бас нэг томоохон өөрчлөлт нь валютын харилцах данс болон М1 мөнгөний хэмжээ тогтмол буурч байгаа ч валютын хадгаламжийн өсөлтийн хэмжээ сүүлийн 5 улиралд дараалан нэмэгдэж 3-р улиралд 74.7% хүрсэн байгаа үзүүлэлт юм.

Зураг 7. Валютын хадгаламж, жилийн өсөлт 2020 он III улирал



Эх сурвалж: "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК судалгаа

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.